



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Додоц оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/186

Улаанбаатар хот

Гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлон,
бохирын цооногийг халдвартгуйжүүлэх ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрсний бохирдоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1, 2 дугаар хорооны гэр хорооллын айл өрхийн, нүхэн жорлон, бохирын цооногийг халдвартгуйжүүлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулахыг Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Халдвартгуйжүүлэлтэд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж зарцуулагдах 2,196,100 (Хоёр сая нэг зуун ерэн зургаан мянга нэг зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш 7 хоногийн дотор санхүүгийн тайланг ирүүлж, үр дүнг эргэн танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, айл өрхүүдэд мэдээ, мэдээллийг хүргэн ажиллахыг хороо (Н.Нямзав, Б.Батзориг)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Санжийжамц)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн
11 дугаар захирамжийн хавсралт

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН НҮХЭН ЖОРЛОН,
БОХИРЫН ЦООНГОГИЙН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТЭД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1.	1,2 дугаар хорооны хэсгийн ахлагч наарт утасны нэгж	ш	6	10,000	60,000
2.	Бензин	л	10	2,410	24,100
3.	Ариутгалын бодис	ш	352	6,000	2,112,000
Нийт үнэ:					2,196,100